



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2011 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 402

Улаанбаатар хот

Г “Улаанбаатар хивс” ХК-ийн 7
нэгдмэл сонирхолтой хувьцаа эзэмшигчдээс
гаргасан тендер саналыг зөвшөөрөх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.1, 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 11 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 57 дугаар заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Улаанбаатар хивс” ХК-ийн нийт 404,829 ширхэг гаргасан хувьцааны 33,3 хувь буюу 134,952 ширхэг хувьцааг нэгдмэл сонирхолтойгоор иргэн Ш.Энхбаяр, О.Мөнхцацрал, Ш.Уламбаяр, Ш.Баярсайхан нар эзэмшдэг ба тус хувьцаат компанийн бусад хувьцаа эзэмшигчдийн өмчлөлд байгаа хувьцаа нэг бүрийг нь 7,100 /долоон мянга нэг зуу/ төгрөгөөс доошгүй үнээр худалдан авах тендер санал гаргасныг зөвшөөрч хүчинтэй байх хугацааг 2011 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн ажлын 60 хоногоор тогтоосугай.

2. Холбогдох хууль, журмын дагуу “ҮЦГТТХТ” ХХК-тай гэрээ байгуулж мөнгөн хөрөнгийг байршуулж, тендер саналаа нийтэд сурталчилж, хуулиар хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлэх, тендер саналын хугацаа дуусмагц ажлын 5 хоногийн дотор тендер саналын хэрэгжилтийн тайланг Хороонд ирүүлэхийг нэгдмэл сонирхолтой этгээдүүдийг төлөөлж буй иргэн/Ш.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

3. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Үнэт цаасны газар/Б.Саруул/, олон нийтэд мэдээлэхийг Тамгийн газар/Д.Нямцэрэн/-т тус тус үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН